



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/102

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, 17.1.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд баримтлах "Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Тус журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангаж, зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шуурхай штаб /Г.Билгүүн/-д даалгасугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

571000502

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын  
2020 оны /11/ тушаалын хавсралт

**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1.Энэ журмын зорилго нь коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, халдварын болзошгүй тохиолдлыг цаг алдалгүй тогтоож, дамжин халдварлахаас сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй явуулах, холбогдох шийдвэрийг шуурхай зохион байгуулах арга хэмжээг зохицуулахад оршино.

1.2.Энэ журам нь гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэг цуцлагдах хүртэл хугацаанд үйлчилнэ.

**Хоёр. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ**

2.1.Газар, хэлтэс коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

2.1.1.Халдвараас сэргийлэх санамж, зөвлөмжийг үйлчилгээний танхим, албан тасалгаа, цахилгаан шат, явган шат, ариун цэврийн өрөө зэрэгт байршуулах;

2.1.2.Халдваргүйжүүлэх бодис, амны хаалт, нүүрний хаалт, бээлий, гар халдваргүйжүүлэх бодис, гарын шингэн саван, гарын цаасан алчуур, цэвэрлэгээний материалын нөөцийг бүрдүүлэх;

2.1.3.Үйлчлүүлэгч болон ажилтны ариун цэврийн өрөөнд гар угаах нөхцөлийг бүрдүүлж гарын саван, халдваргүйжүүлэх уусмалыг байршуулах;

2.1.4.Ажлын байранд анхны тусламжийн иж бүрдэл, амны хаалт, нэг удаагийн өмсгөл, гар халдваргүйжүүлэгч, бээлий, хог хаягдлын уут зэрэг хэрэгслээр хангасан ТУСГААРЛАХ ӨРӨӨ бэлтгэх;

2.1.5.Халдварын сэжигтэй тохиолдлыг тусгаарлах ажлыг хариуцсан 2-3 ажилтныг томилох, томилогдсон ажилтнуудад хамгаалалтын хувцас хэрэглэлийг зааврын дагуу хэрэглүүлэх;

2.1.6.Ажилтан болон үйлчлүүлэгчдийг qr.119.mn бүртгэлийн системд бүртгүүлэх, биеийн халуун шалгах, асуумж бөглүүлж ажлын байранд нэвтрүүлэх;

2.1.7.Ажилтан болон үйлчлүүлэгчид өвчний шинж тэмдэг илэрсэн, халуунтай байвал эрүүл мэндийн байгууллагад хандахыг зөвлөн буцаах, энэ тухай бүртгэл хөтлөх;

2.1.8.Амны хаалтгүй иргэнийг байгууллагад нэвтрүүлэхгүй байх;

2.1.9.Ажилтан хооронд болон бусад иргэн, үйлчлүүлэгчтэй 1.5 метрээс дотогш зайд харилцахгүй байх нөхцлийг бүрдүүлэх, ажилтнуудын ширээ, сандлыг 1.5 метрийн зайд байрлуулах, өрөө тасалгаанд 1.5-2.0 метрийн зайн тэмдэглэгээг хийх, мөрдөх;

2.1.10.Хурал, уулзалт, сургалтыг цахимаар зохион байгуулах, танхимаар зохион байгуулах нөхцөлд халдвар хамгааллын дэглэмийг баримтлан оролцогчдын суудлыг 1 метрээс багагүй зайд байрлуулах, хурлын танхимын агаар сэлгэлт хийх, хангалтын материал /цаасан алчуур, гар ариутгагч/ бүрдүүлэх;

2.1.11.Санал, хүсэлт, өргөдлийг утсаар болон цахимаар хүлээн авч, шийдвэрлэх, хариу хүргүүлэх;

2.1.12.Нийт газар, хэлтсийн албан хаагчдын 5, 10, 30, 50 хүртэл хувийг ажлын байранд, бусад албан хаагчдыг гэрээр ажиллуулах зохион байгуулалт, ажлыг хуваарийг урьдчилан бэлтгэж байх. Албан хаагчдыг цахимаар гэрээс нь ажиллуулах, ээлжээр ажиллуулах бэлтгэл хангах;

2.1.13.Ажилтан өөрөө болон гэр бүлийн гишүүн нь тусгаарлагдсан, ажиглалтын хугацаа дуусаагүй тохиолдолд ажлын байранд ирүүлэхгүй байх.

2.2.Ажилтан коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

2.2.1.Ажлын байранд урьдчилан сэргийлэх арга хэмжээ, цэвэрлэгээ ариутгалын заавар болон эрүүл мэндийн байгууллагаас иргэнд зориулж гаргасан заавар зөвлөмжийг дагаж мөрдөх;

2.2.2.Ажлын байранд ажилтнууд дотоод гадаад орчинд амны хаалт заавал зүүж хэрэглэх, гарыг бохирдсон тухай бүр савандаж угаах, халдваргүйжүүлэх бодисоор халдваргүйжүүлэх, бусадтай гар барихгүй байх, бусадтай хувийн эд зүйлсээ солихгүй байх;

2.2.3.Иргэнд үйлчилгээ үзүүлж буй ажилтнууд амны болон нүүрний хаалт, нэг удаагийн бээлий, малгайг тогтмол зүүж ажиллах;

2.2.4.Ажилтан хооронд болон бусад иргэн, үйлчлүүлэгчтэй 1.5-2.0 метрийн зайнаас харилцах;

2.2.5.Ажил үүргээ гэрээсээ гүйцэтгэх хугацаанд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэх, өдөр бүр ажлын явц, үр дүнг шууд удирдлагад тайлагнах, шаардлагатай тохиолдолд ажлын байранд ирж ажиллах, ажлын хэвийн ажиллагааг тасралтгүй хангаж, тухайн хугацаанд гүйцэтгэх ажилд байнгын хяналт тавьж хугацаанд нь хийж гүйцэтгэхэд онцгойлон анхаарах, оршин суугаа газраас өөр тийшээ явахгүй байх, гар утсаа нээлттэй байлгаж утасны дуудлага, албаны цахим хаяг, газар, хэлтсийн мэдээлэл солилцох цахим орчины мэдээлэлд тухай бүр хариу өгөх;

2.2.6.Ажилтан бүр өөрийн болон гэр бүлийн эрүүл мэнд, дархлааг дэмжихэд анхаарах, эрүүл мэндийн байгууллагын өгч буй санамж зөвлөгөөг дагаж хэрэгжүүлэх.

### **Гурав. Цэвэрлэгээ, ариутгал**

3.1.Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх цэвэрлэгээ, ариутгал, халдвар хамгааллын дэглэм сахиулах дараах арга хэмжээг газар, хэлтэс хэрэгжүүлж, хяналт тавина:

3.1.1.Өрөө тасалгаанд 2 цаг тутам 10-15 минут агаар сэлгэлт хийх;

3.1.2.Салхивчгүй өрөө тасалгаанд өдөрт 2 удаа чийгтэй цэвэрлэгээ хийх;

3.1.3.Барилга байгууламж, гаднах орчны талбайг эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж зааврын дагуу өөрсдийн нөөц бололцоогоор ариутгах;

3.1.4.Ажлын байрны өрөө тасалгаанд өдөр бүр чийгтэй цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтийг хийж, ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур, шатны бариул, хаалганы бариул, цахилгаан шатны товчлууур, унтраалга, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн гадаргуу зэрэг хүний гар хүрэх эд зүйлсийн гадаргууг 2 цаг тутам халдваргүйжүүлэх бодистой уусмалаар арчих, халдваргүйжүүлэх;

3.1.5.Ажилтнууд өөрийн ажлын ширээ сандал, компьютер, шүүгээ зэрэг албан тасалгаанд буй хүний гар хүрэх гадаргууг 2 цаг тутамд чийгтэй алчуураар арчих, халдваргүйжүүлэх;

3.1.6.Цэвэрлэгээнд хэрэглэсэн алчуур, хэрэгслийг цэвэрлэж халдваргүйжүүлсний дараа цэвэр усаар зайлж хатааж хадгалах;

3.1.7.Ажилтнууд хувийн ариун цэврийг сахих, нийтийн хэрэгцээний байр талбай, ариун цэврийн өрөөг зүй зохистой ашиглах, гарын саван, ариун цэврийн цаасыг зохистой хэрэглэх;

3.1.8.Байгууллагаас албан хаагчдыг ариутгалын бодис, амны хаалт, цэвэрлэгээний хэрэгслээр хангана.

### **Дөрөв. Халдварт өвчний шинж тэмдэг илэрвэл хэрэгжүүлэх арга хэмжээ**

4.1.Сүүлийн 14 хоногийн хугацаанд онош батлагдсан хүнтэй ойрын хавьтал болсон, халуурах, хуурай ханиалгах, ядарч сульдах, цэр гарах, амьсгал давчдах, булчин, хоолой, толгой өвдөх, суулгах, хамар битүүрэх зэрэг шинж тэмдэг илэрсэн хүнийг сэжигтэй тохиолдол гэж үзнэ.

4.2.Ажилтан ажлаа хийж байх явцад сэжигтэй тохиолдлын шинж тэмдэг илэрвэл дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:



4.2.1.Сэжигтэй тохиолдлын мэдээлэл авмагц томилогдсон ажилтан тусгаарлах өрөөнөөс амны хаалт, бээлий, улавч, хамгаалалтын хувцас өмсөж тухайн хүнийг урьдчилан бэлтгэсэн тусгаарлах өрөөнд хүргэх;

4.2.2.Хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан удирдлагад мэдээлж, эрүүл мэндийн байгууллага /ХӨСҮТ 119/-д нэн даруй дуудлага, мэдээлэл өгөх;

4.2.3.Сэжигтэй тохиолдолтой 15 минутын турш 1 метрээс дотогш зайд харьцсан хүнийг ойрын хавьтал гэж үзэх ба ойрын хавьтлыг ажлын өрөөнд нь тусгаарлах арга хэмжээ авах;

4.2.4.Сэжигтэй тохиолдлын шинжилгээний хариу гартал тусгаарлах өрөөг битүүмжилж эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийг дагах;

4.2.5.Сэжигтэй тохиолдлын онош батлагдсан тохиолдолд голомтод халдваргүйжүүлэлтийн багт дуудлага өгч ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэх;

4.2.6.Байгууллагын Шуурхай штаб /99058329/-т нөхцөл байдлыг шуурхай мэдээлэх;

4.2.7.Ажилтны халдвар авсан нь баталгаажсан тохиолдолд ойр харилцаж байсан бусад ажилтнууд, харилцагчдын мэдээллийг Шуурхай штаб, Эрүүл мэндийн байгууллагад нэн даруй мэдээлэх, тэдгээр хүмүүст өөрийгөө тусгаарлах талаарх зөвлөгөө, мэдээллийг шуурхай өгөх.

4.3.Ажилтан гэртээ байх үед болон ажилтны гэр бүлийн гишүүнд сэжигтэй тохиолдлын шинж тэмдэг илэрвэл дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.3.1.Ажилтан гэртээ байх хугацаанд өөрт эсвэл гэр бүлийн гишүүнд өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд халдвараас урьдчилан сэргийлж ажилдаа ирэлгүй өөрийн газар, хэлтсийн удирдлага болон эрүүл мэндийн байгууллагад үнэн зөв мэдээлж, эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу арга хэмжээ авах;

4.3.2.Гэрийн тусгаарлалтад байгаа тохиолдолд эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийг баримтлан өдөр бүр эрүүл мэндийн байдлыг харьяалах газар, хэлтсийн удирдлагад мэдэгдэх;

4.3.3.Эрүүл мэндийн асуудлаар харьяа өрхийн эмнэлэг болон тусгай дугаарт хандаж зөвлөгөө авах, газар, хэлтсийн даргад өдөр бүр мэдээлэх.